

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн байцгаана уу,

Бүх сурагчид маань хичээлдээ бүрэн орж энэ долоо хоног амжилттай дуусч байна. Нийт сурагчдын 1.9 хувь нь хичээлд ирээгүй ирцийн мэдээ бидэнд байна. Ханиад томуу элбэг энэ үед 1.9 гэдэг бол их сайн үзүүлэлт. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаанд амралт аялалын төлөвлөгөө нөлөөлж магадгүй байна. Сурагчдын хичээл сурлаганд аль болох нөлөөлөхгүй талаас нь та бүхэн аялалаа төлөвлөвөл бид баяртай байх болно.

Сургууль руу орж ирсэн бүх хүний халууныг бид тогтмол хэмжиж байгаа. Энэ нь сургуулийн хамт олны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахын төлөө бидний хийж байгаа ажлын нэг хэсэг нь юм.

12 сарын 16-ны Лхагва гарагт мини НҮБ-ын хуралдаан болно. Энэ арга хэмжээ жил бүр уламжлал болгон зохиогддог. Ирэх долоо хоногт хичээллэж дуусаад сурагчдын өвлийн амралт эхэлнэ. Та бүхэн амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй.

Захирал, Greg Rayl

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Энэ долоо хоногт бага сургуулийн сурагчид хичээлдээ орж эцэг эхчүүд, сурагчид бүгд баяртай байна. Хичээл сургалтын ажил жигдэрсэнд болон та бүхний уйгагүй ажиллагаанд талархал илэрхийлье. Багш сурагчид маань сургалтын хөтөлбөрийн хүрээнд судлах хичээлийн сэдвээ хуваарийн дагуу тасралтгүй үргэлжлүүлж Мини НҮБ-ын хуралдаандаа бэлтгэж байна.

Жил бүр ОУДС сурагчдынхаа дунд НҮБ-ын Мини Хуралдаан зохион байгуулдаг. Энэ хурлын үеэр сурагчид дэлхийн улс орнуудын талаар их зүйлийг мэдэж НҮБ хуралдаанаа хэрхэн явуулдаг талаар туршлага олж авдаг юм. Сурагчид энэ хуралдаанд бэлтгэж өөрсдийн сонгож авсан орны талаар мэдээлэл бэлтгэдэг. Энэ арга хэмжээнд оролцохын тулд сурагчид маань шаргуу бэлтгэж жил бүр амжилттай оролцдог. Сурагчид хурлын протокол хөтлөх, НҮБ-ын жинхэнэ гишүүд шиг мэргэжлийн түвшинд албан ёсны хувцаслах зэргээр олон зүйлд суралцдаг. Эцэг эхчүүд та бүхэн хүүхдүүддээ ирэх Лхагва гарагт болох хуралдаанд бэлтгэхэд нь туслаарай. Сурагчид бэлтгэлээ сайн хийвэл энэ арга хэмжээ амжилттай сайн явагдах болно.

2-р улирал буюу 1-р семестр нэг сарын 29-нд дуусч сурагчдын дүн 2 сарын 5-нд гарна. Манай сургуулийн танхимд хичээллэх өдөр 180 хоног байдаг. 1 сарын 29-нд бид 91 дэх хоногоо дуусгана. Та бүхэнд тодруулж хэлэхэд Кристмасын баяр болон Шинэ Жилийн баярын амралт эхэлсэнээр хичээлийн жилийн улирал дуусдаггүй. 9-11-р ангийн сурагчдын шалгалт 1 сарын 20-нд, IV дипломын урьдчилсан шалгалт 1 сарын 18-ны Даваа гарагт эхэлнэ. 1 сарын 25-нд шалгалт дуусна. Та бүхэн сайхан амраарай.

Дунд Сургуулийн Эрхлэгч, Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Энэ долоо хоногт сурагчдын маань хичээл эхэлж тэд хичээлдээ шамдан завгүй байна. Сурагчдын Зөвлөлөөс зохион байгуулсан Wacky Hair Day-д бага сургуулийн олон сурагчид идэвхтэй оролцсоныг харахад таатай байна. Хичээл хаагдсан үеэр сурагчид хэсэг хэсгээрээ сургууль дээрээ ирж багш нартайгаа бататгах хичээл хийж байсан. Энэ үеэр дуу хөгжмийн багш Сарантунгаа сурагчиддаа зааж бэлтгэсэн хөгжим, бүжгийн тоглолтоо бидэнд өчигдөр сонирхууллаа. Энэ тоглолт их сонирхолтой байсан бөгөөд тоглолтонд оролцсон сурагчиддаа баяр хүргэе.

Энэ улиралд 2 долоо хоногийн дугуйлан хичээллэх хугацаа үлдээд байна. (дараагийн долоо хоног болон өвлийн амралтын дараах нэг долоо хоног) 1-р семестер 1 сарын 29-ний Баасан гарагт дуусч сурлагын дүн 2 сарын 5-ны Баасан гарагт сурагчдад очно. Бид бараг өдөр бүр гадаа гарч тоглож байгаа тул та бүхэн хүүхдүүддээ малгай ороолт, бээлий өмсгөж дулаан хувцаслаарай. (Гадаа эрс хүйтэрсэн тохиолдолд бид сурагчдыг дотор тоглуулах зохион байгуулалт хийдэг)

Бага Сургуулийн Эрхлэгч, Jan Wiggins

Сайн дураараа ярилцлага өгөх хүмүүс бидэнд хэрэгтэй байна.

Эрхэм Хүндэт Эцэг Эхчүүд ээ,

“Түүхийн хугацаанд янз бүрийн шалтгаанаар хүмүүс нэг орноос нөгөө орон луу нүүж суурьшаар иржээ” гэсэн энэ сэдвийг 4-р ангийн сурагчид судлах гэж байна. Хүмүүс яагаад цагаачилдаг шалтгаануудыг болон цагаачлалын үйл явцын талаарх туршлагаас сурагчид маань суралцах болно.

Сургууль дээр байгаа мэдээлэлийн эх сурвалжуудаас гадна сурагчид маань хүмүүсээс ярилцлага авч туршлага судлах хүсэлтэй байгаа. Магадгүй та бүхний эмээ өвөө, хамаатан, эсвэл найз нөхдийн тань дунд ямар нэгэн зөрчилдөөн, улс төр, эдийн засгийн шалтгааны улмаас болж цагаачилсан хүмүүс байж магадгүй.

Бидэнтэй нүүр тулан эсвэл e-mail, Skype-р дамжуулан уулзаж, бидний асуултанд хариулах цагаач иргэдтэй ярилцлага хийхийг бид хүсч байна.

Та бүхэн бидэнд энэ тал дээр туслах буюу биднээс асуух зүйл байвал Mrs. Shelly D' Souza, Ms. Faber нартай e-мэйлээр холбоо барина уу.

s.dsouza@isumongolia.edu.mn

m.faber@isumongolia.edu.mn

СУРАГЧДЫН ЗӨВЛӨЛӨӨС

ОУДС-ийн Сурагчдын Зөвлөл олон улсын Хатагтай нарын нийгэмлэгийн үйл ажиллагааг дэмжиж эрүүл ахуй, ариун цэврийн жижиг бүтээгдэхүүн цуглуулж хандивлах гэж байна. Сурагчид та бүхэн өвлийн амралтаараа явахдаа зочид буудлуудад үнэгүй тавигддаг үсний шампун, шүдний сойз, сам, ангижруулагч, гарын тос гэх мэт жижиг зүйлсийг цуглуулж ирнэ үү. Амралтын дараа бид эдгээр зүйлсийг цуглуулан авч олон улсын Хатагтай нарын нийгэмлэгт хандивлах болно.